



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/61

Булган сум

Сумын Засаг дарга нарыг гадаадад албан
томилолтоор ажиллахыг түр зогсоох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.21 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн зарим сумдын өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрч болзошгүй нөхцөл байдал үүсч, мөн хаврын мал төллөлтийн ажил, тариалангийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга нарыг 2023 оны 02 дугаар 08-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэл гадаадад албан томилолтоор ажиллахыг түр зогсоосугай.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжинд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ